



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шарга сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2024/53/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Цэгц богд төв аудит ХХК-ийн Ахлах аудитор: Р.Цанжидмаа

Утас: 99029885 Цахим хаяг: tsania.0215@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.01.30

№

6

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шарга сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шарга сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус Эрүүл мэндийн төв тайлант онд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 2017 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нэг иргэнд ногдох санхүүжилт 422,918.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс байр ашиглалттай холбоотой зардлын санхүүжилт 61,722.6 мянган төгрөг, Эрүүл мэндийн яамнаас өр барагдуулахаар 20,000.0 мянган төгрөг тус тус авсан байна. Хандив тусламжаар 34,055.6 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, аж ахуй, хангамжийн материал үнэ төлбөргүй орлого авчээ.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 4 хөтөлбөр, 77 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 6 арга хэмжээг бүрэн, 70 арга хэмжээг 70.0-90.0 хувь, 1 арга хэмжээ 50.0 хувь буюу нийт дүнгээр 96.0 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд сумын Засаг даргаас 86.9 хувиар, Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээгээр 70.99 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Дансны код	Балансын зүйл	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	27,153.8	42,305.5
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,656,843.0	1,553,998.8
	Нийт хөрөнгийн дүн	1,683,996.8	1,596,304.3
	Нийт өр төлбөрийн дүн	11,934.3	11,338.5
	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,672,062.5	1,584,965.8
	Өр төлбөр, цэвэр өмчийн дүн	1,683,996.8	1,596,304.3
Орлого үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,266,085.3	556,117.0
	Үйл ажиллагааны зардлын дүн	778,339.6	643,319.7
	Үйл ажиллагааны үр дүн	1,487,745.7	(87,096.7)
Цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийсэн үлдэгдэл	184,316.8	1,672,062.5
	Тайлант оны үр дүн	1,487,745.7	(87,096.7)
	Эцсийн үлдэгдэл	1,672,062.5	1,584,965.8
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	700,976.3	505,660.6
	Үйл ажиллагааны зардлын дүн	651,534.2	485,660.6
	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	49,442.1	770.5
	Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(59,356.3)	(778.0)
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	0.00	0.00
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(9,914.2)	(7.4)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,957.5	43.3
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	43.3	35.9
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага цэвэр зээлийн дүн		504,648.9
	Урсгал зардал		504,648.9
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		504,641.4
	Эрүүл мэндийн даатгалын сангаас		422,918.8
	Орон нутгийн төсвөөс		61,722.6
	Урьд оны үлдэгдлээс		
	Туслах үйл ажиллагааны орлогоос		20,000.0

Аудитаар нийт 9,297.0 мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрснээс, 491.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 3,398.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар 2 албан шаардлага өгсөн.

Төлбөрийн акт

1. Улирлын үр дүнгийн урамшуулал олгох шийдвэр гарсан ажилтанд 491.1 мянган төгрөгийн урамшуулал дутуу олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.3-т "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана", 3 дугаар зүйлийн 3.1-т "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд ажлын үр дүн, гүйцэтгэлийг нь үндэслэн мөнгөн урамшуулал олгоно", 3.2-т "Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үндэслэн үндсэн цалингийн 10-20 хувиар сар бүр тооцож, улирал тутам олгоно" гэж заасантай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу олгосон урамшуулал 491.1 мянган төгрөгийг нөхөн олгох төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

1. Тендерт шалгараагүй 3 аж ахуйн нэгж байгууллагаас 8,805.9 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерт шалгарсан этгээтээс худалдан авалт хийж байх албан шаардлага хүргүүлсэн.

2. Эм боох материалын үлдэгдэлд хугацаа дууссан 4 нэр төрлийн 1164 ширхэг 4,819.7 мянган төгрөгийн эм бэлдмэл байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-т "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх"-тэй нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Дотоодын хяналтыг сайжруулан хугацаа дууссан эмийг холбогдох журмын дагуу шийдвэрлэж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил	/сая төгрөгөөр/				
		Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шарга сумын Эрүүл мэндийн төв	3	9.3	1	0.5	2	8.8	-	-	-	-	-	-
Дүн	3	9.3	1	0.5	2	8.8	-	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			